



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 18 өдөр

Дугаар

8/2025

Улаанбаатар хот

### "Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ-ын эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 2,647,823.64 (хоёр сая зургаан зуун дөчин долоон мянга найман зуун хорин гурван төгрөг жаран дөрвөн мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Сүхбаатар дүүргийн "Сүхбаатар дэвшил" ОНӨААТҮГ балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг "Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ (Б.Мөнхцэцэг)-т зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сүхбаатар дүүргийн "Сүхбаатар дэвшил" ОНӨААТҮГ (Б.Амгалан)-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын  
 2024 оны дугаар сарын 18-ны өдрийн  
 дугаар тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: "Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ

| д/д                                 | Хөрөнгийн нэр                 | Ашигласан жил | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэгжийн үнэ | Нийт үнэ            | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг      | Шилжүүлэх байгууллага           | Шилжүүлэн авах байгууллага                     |
|-------------------------------------|-------------------------------|---------------|-------------|------------|-------------|---------------------|-----------------------|---------------------|---------------------------------|--|
| 1                                   | Хөлдөөгч /sky worth 110w/     | 3             | ш           | 2          | 327,181.82  | 654,363.64          | 508,678.08            | 145,685.56          |                                 |  |
| 2                                   | Угаалгын машин /midea100-502/ | 5             | ш           | 2          | 299,900.00  | 599,800.00          | 280,125.20            | 319,674.80          |                                 |  |
| 3                                   | Аяга таваг ариутгагч          | 4             | ш           | 2          | 220,000.00  | 440,000.00          | 135,660.48            | 304,339.52          | "Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ | Сүхбаатар дүүргийн "Сүхбаатар дэвшил" ОНӨААТҮГ |
| <b>Машин тоног төхөөрөмжийн дүн</b> |                               |               |             |            |             | <b>1,694,163.64</b> | <b>924,463.76</b>     | <b>769,699.88</b>   |                                 |  |
| 1                                   | Гал тогооны ширээ             | 7             | ш           | 3          | 150,000.00  | 450,000.00          | 281,288.43            | 168,711.57          |                                 |  |
| 2                                   | Ширээ                         | 10            | ш           | 1          | 85,000.00   | 85,000.00           | 85,000.00             | 0.00                |                                 |  |
| 3                                   | Урт сандал                    | 10            | ш           | 4          | 38,000.00   | 152,000.00          | 152,000.00            | 0.00                |                                 |  |
| 4                                   | Ажлын ширээ                   | 6             | ш           | 2          | 133,330.00  | 266,660.00          | 137,824.00            | 128,836.00          |                                 |  |
| <b>Тавилга эд хогшлын дүн</b>       |                               |               |             |            |             | <b>953,660.00</b>   | <b>656,112.43</b>     | <b>297,547.57</b>   |                                 |  |
| <b>Нийт хөрөнгийн дүн</b>           |                               |               |             |            |             | <b>2,647,823.64</b> | <b>1,580,576.19</b>   | <b>1,067,247.45</b> |                                 |  |